



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 1102

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрлийг хүчингүй болгож,  
нөхөн олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.17 дах заалт, 25 дугаар зүйлийн 25.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батцогтын Жимсээ нь Баянгол дүүргийн Засаг даргын 2015 оны 04 сарын 15-ны өдрийн А/260 дугаар захирамжаар өөрийн нэрийг сольсон тул Эрүүл мэндийн сайдын 2014 оны 254 дүгээр тушаалаар олгосон эмчлэх үйл ажиллагаа эрхлэх ИЭТ0003690 сери, 0003690 дугаарын зөвшөөрлийг хүчингүйд тооцож, Батцогтын Маралгоо нэрээр ИЭТ0005062 сери, 0005062 дугаартай эмчлэх зөвшөөрлийг нөхөн олгосугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгон, төвийн цахим хуудас, зөвшөөрлийн мэдээний санд байршуулж нийтэд мэдээлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал (Ч.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга (С.Ламбаа)-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080330